



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2025/001/НА-СТА-ЗГТС

Цахим хуудас:
www.Open.audit.mn
Архангай аймаг
2025 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141
Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn
Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860
Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn
Аудитор Н.Энхчимэг
Цахим хаяг: Enkhchimegn@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

2.АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2024. 02. 24 № 48
танай _____-ны № _____-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР,
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГА Х.АЛТАНТУЯА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Хөдөлмөр, эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын онцлох асуудал

Тайлант онд Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор малгүй болон цөөн малтай малчин өрхийг малжуулахад 2,400,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг 19 сумын 300 малчинд олгосон байна. Малжуулах арга хэмжээний зардал өмнөх оноос 99.9 хувиар өссөн байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 5 үйл ажиллагааны 22 арга хэмжээг санхүүжүүлэхээр 4,146,359.5 мянган төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 3,845,503.9 мянган төгрөгийг зарцуулж 300,855.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Төсвийн үлдэгдэл нь хөгжлийн бэрхшээлийн иргэний ажлын байрыг дэмжих, аж ахуй эрхлэлтийг дэмжих, ажил мэргэжлийн чиг баримжаа, зөвлөгөө өгөх, хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, түр ажлын байрыг дэмжих, Засгийн газрын, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны зардлаас хэмнэснээс шалтгаалсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 18 үндсэн зорилтын хүрээнд 46 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *T. Baygalmaa* Т.БАЙГАЛМАА



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр /

| Код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------|---|-------------------------|-------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 2,059,934,768.30 | 4,152,597,724.09 |
| 33 | АВЛАГА | 2,059,934,768.30 | 4,152,597,724.09 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 91,036,865.30 | - |
| 335 | Бусад авлага | 1,968,897,903.00 | 4,152,597,724.09 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 1,968,897,903.00 | 4,152,597,724.09 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 2,059,934,768.30 | 4,152,597,724.09 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 2,059,934,768.30 | 4,152,597,724.09 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 2,059,934,768.30 | 4,152,597,724.09 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 2,059,934,768.30 | 4,152,597,724.09 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 2,059,934,768.30 | 2,059,934,768.30 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 2,092,662,955.79 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 2,059,934,768.30 | 4,152,597,724.09 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|--|---------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,928,651,000.00 | 4,156,259,500.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,928,651,000.00 | 4,156,259,500.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,928,651,000.00 | 4,156,259,500.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,927,651,000.00 | 4,156,259,500.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 837,133,000.00 | 4,146,359,500.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 173,448,000.00 | 9,900,000.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдэлээс санхүүжих | 917,070,000.00 | |
| 120009 | Бусад орлого | 1,000,000.00 | - |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,330,753,909.70 | 2,018,396,694.21 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,330,753,909.70 | 2,018,396,694.21 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 41,902,130.00 | 40,304,500.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 41,902,130.00 | 40,304,500.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 41,902,130.00 | 40,304,500.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,288,851,779.70 | 1,978,092,194.21 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 576,243,004.70 | 605,999,500.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 576,243,004.70 | 605,999,500.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 11,450,000.00 | 310,755,650.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 11,450,000.00 | 310,755,650.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | - | 91,036,865.30 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 91,036,865.30 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 701,158,775.00 | 970,300,178.91 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 701,158,775.00 | 970,300,178.91 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 597,897,090.30 | 2,137,862,805.79 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 597,897,090.30 | 2,137,862,805.79 |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-----|--|---------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 1,928,651,000.00 | 4,247,296,365.30 |

Архангай аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

| | | | |
|---------|--|------------------|------------------|
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,928,651,000.00 | 4,247,296,365.30 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,928,651,000.00 | 4,247,296,365.30 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,927,651,000.00 | 4,247,296,365.30 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 837,133,000.00 | 4,146,359,500.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 173,448,000.00 | 9,900,000.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдэлээс санхүүжих | 917,070,000.00 | 91,036,865.30 |
| 120009 | Бусад орлого | 1,000,000.00 | - |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 2,633,790,775.00 | 5,217,596,544.21 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,633,790,775.00 | 5,217,596,544.21 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 41,902,130.00 | 40,504,350.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 41,902,130.00 | 40,504,350.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 41,902,130.00 | 40,504,350.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 2,591,888,645.00 | 5,177,092,194.21 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,788,243,004.70 | 3,804,999,500.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 1,788,243,004.70 | 3,804,999,500.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 11,450,000.00 | 310,755,650.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 11,450,000.00 | 310,755,650.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 91,036,865.30 | 91,036,865.30 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 91,036,865.30 | 91,036,865.30 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 701,158,775.00 | 970,300,178.91 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 701,158,775.00 | 970,300,178.91 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | (705,139,775.00) | (970,300,178.91) |
| 14 | Бусад эх үүсвэр | 705,139,775.00 | 970,300,178.91 |
| 145004 | Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх | 705,139,775.00 | 970,300,178.91 |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 705,139,775.00 | 970,300,178.91 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|---------------------------------------|-------------------|---|
| C01 | Ү1 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 2,059,934,768.30 | 2,059,934,768.30 |
| C08 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 2,059,934,768.30 | 2,059,934,768.30 |
| D01 | 2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 2,059,934,768.30 | 2,059,934,768.30 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 2,092,662,955.79 | 2,092,662,955.79 |
| D09 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 4,152,597,724.09 | 4,152,597,724.09 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|-----------------------|--|-----------------------|------------------|-----------------|
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 4,146,359,500.00 | 4,156,259,500.00 | (9,900,000.00) |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 4,146,359,500.00 | 4,156,259,500.00 | (9,900,000.00) |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 60,600,000.00 | 40,504,350.00 | 20,095,650.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 60,600,000.00 | 40,504,350.00 | 20,095,650.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 60,600,000.00 | 40,504,350.00 | 20,095,650.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 4,085,759,500.00 | 4,115,755,150.00 | (29,995,650.00) |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 4,085,759,500.00 | 4,115,755,150.00 | (29,995,650.00) |

Архангай аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

| | | | | |
|---------|--|------------------|------------------|------------------|
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 4,085,759,500.00 | 3,804,999,500.00 | 280,760,000.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 310,755,650.00 | (310,755,650.00) |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 5,207,696,544.21 | 5,217,596,544.21 | (9,900,000.00) |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 4,146,359,500.00 | 4,146,359,500.00 | - |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 4,146,359,500.00 | 4,146,359,500.00 | - |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 91,036,865.30 | 100,936,865.30 | (9,900,000.00) |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 9,900,000.00 | (9,900,000.00) |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 91,036,865.30 | 91,036,865.30 | - |
| 14 | БУСАД ЭХ ҮҮСВЭР | 970,300,178.91 | 970,300,178.91 | - |
| 145005 | Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх | 970,300,178.91 | 970,300,178.91 | - |

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа, зөрчил илрээгүй **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.